

**ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН 2020 ОНЫ
1 ДҮГЭЭР САРЫН ЦАГ ҮЕИЙН МЭДЭЭ**

НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ХҮРЭЭНД

Аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлыг 2 удаа зохион байгуулж, 6 асуудлыг хэлэлцэж шийдвэрлэсэн. Үүнд 3 иргэнийг Засаг даргын “Жуух бичиг”-ээр шагнахаар шийдвэрлэж, өргөдөл, гомдол, санал, хүсэлтийн жилийн эцсийн тайланг танилцуулсан. Мөн Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн 2019 оны жилийн эцсийн хэрэгжилтийг танилцуулж, хэлэлцүүлсэн.

Аймгийн Удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнийг 2 удаа зохион байгуулж, нийт 10 үүрэг даалгавар өгч, хэрэгжилтийг хангуулан ажилласан.

2019 оны жилийн эцсийн байдлаар аймгийн хэмжээнд 452.0 мянган толгой мал тоологдсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулбал малын тоо нийт дүнгээрээ 5.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

ХОЁР. ЭДИЙН ЗАСАГ, ТӨСӨВ, САНХҮҮГИЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

2020 оны 01 дүгээр сарын Орон нутгийн татварын орлогын төлөвлөгөө 170657.0 мян төгрөг төвлөрүүлэхээс, 170657.0 мян төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт 100 хувьтай байна.

Орон нутгийн төсвийн байгууллагуудын 690.2 сая төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын 754.0 сая төгрөгийн зарцуулалтын эрх төсвийн хуваарийн дагуу бүрэн нээгдэж төрийн сангийн гүйлгээ хэвийн явагдаж байна.

Статистикийн чиглэлээр: 2019 оны жилийн эцсийн мал тооллогын ажил дуусч урьдчилсан дүнгээр 452 мянган толгой мал тоологдлоо.

Хүн ам, орон сууцны тооллогын бэлтгэл ажлын хүрээнд тоологч, шалгагч, аймаг сумдын тооллогын комиссын гишүүд, сум багийн түр товчооны гишүүдэд сургалт зохион байгуулж, тооллогын ажил 2020 оны 01 дүгээр сарын 09-ний өдрөөс 15-ны өдрүүдэд орон нутагт зохион байгуулагдлаа.

Санхүүгийн хяналт аудитын чиглэлээр: Орон нутгийн болон улсын төсвийн байгууллага, орон нутгийн өмчит байгууллагууд, орон нутгаас татаас авдаг хувийн цэцэрлэгүүдээс бүрдсэн 81 байгууллагын шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт хийлээ. 2019 оны жилийн эцсийн байдлаар тус хуулийн хэрэгжилт 89.7 хувьтай 4 дүгээр улирлын тайлан бүрэн илгээсэн.

Нийгмийн даатгалын сангаас олгосон:Тэтгэвэр

№	Төрөл	2019.01.24		2020.01.24		Шинээр тогтоолгосон
		Хүний тоо	Тэтгэврийн дүн /мян, төг/	Хүний тоо	Тэтгэврийн дүн /мян, төг/	
1	Өндөр настан	1654	635159,4	1748	717865,3	94
2	Хөгжлийн бэрхшээлтэй	296	80684,7	371	101870,0	75
3	Тэжээгчээ алдсан	123	33565,1	134	39832,2	11
4	Үйлдвэрийн осол	51	25128,2	27	11523,1	24
Нийт дүн		2124	774537.4	2280	871090.6	204

Нийгмийн даатгалын сангаас олгосон: Тэтгэмж

№	Төрөл	2019.01.24		2020.01.24	
		Хүний тоо	Тэтгэмжийн дүн /мян. төг/	Хүний тоо	Тэтгэмжийн дүн /мян. төг/
1	ХЧТА тэтгэмж	107	10911,3	63	8605,9
2	ЖБА тэтгэмж	16	18802,3	16	22713,9
3	Оршуулга	4	4000,0	3	3000,0
4	ҮОМШӨ-ХЧТА	0	0	0	0
5	Ажилгүйдэл	13	28928,2	52	32524,1
	Нийт дүн	140	62641,8	134	66843,9

Сайн дурын даатгал:

Сайн дурын даатгалын хамрагдалт	2019.01.24	2020.01.24
Шинээр	12	150
Мөнгө тушаасан	229	252
Тушаасан мөнгөн дүн / мян төг/	17925.9	22683.5

ГУРАВ. ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Эрх зүйн сургалт, сурталчилгааны чиглэлээр: 2020 оны 1 дүгээр сарын 8-ны өдөр Улаанбаатар төмөр замын 3 дугаар ангийн 32 ажилтанд “Зөрчлийн тухай хууль”-иар, 1 дүгээр сарын 14-ний өдөр ХАСХОМ бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий 7 албан хаагчид “Албан тушаалтны хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө орлогын мэдүүлгийг бүртгэх, хянах, хадгалах эрх бүхий албан тушаалтны үйл ажиллагаа, тайлан мэдээ ирүүлэх, гаргахад анхаарах асуудал” сэдвээр сургалт зохион байгуулж 307 гарын авлага материал тараасан.

Архивын ажлын чиглэлээр:

Архивын баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх ажлын хүрээнд 6 хөмрөгийн 44 хадгаламжийн нэгжийн 754 заалт бүхий 4081 хүний нэр, 1707 байгууллагын нэр, 2356 газар зүйн нэр, нийт 1617 хуудас баримтыг цахимжуулж, 961 хуудас баримтыг скайнердан оруулсан байна. Архивын баримтаас 36 иргэнд лавлагаа мэдээллээр үйлчилгээ үзүүлсэн байна.

Архивын тасгийн 2020 оны хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу Сүмбэр сумын Засаг даргын Тамгын газрын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж гарсан зөрчил, дутагдлыг арилгуулах талаар хугацаатай үүрэг, заавар зөвлөгөөг өгч шалгалтын талаарх илтгэх хуудсыг хүргүүлсэн.

2020 оны 01 дүгээр сарын 06, 11-ний өдрүүдэд архив, албан хэрэг хөтлөлтийн чиглэлээр Мал эмнэлгийн газар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын албан хаагчдад сургалт зохион байгуулсан. Сургалтад 45 албан хаагч хамрагдсан.

Төрийн архивын нөхөн бүрдүүлэлтээр Шивээговь сумын Ерөнхий боловсролын 3 дугаар сургуулийн байнга хадгалах 93 хадгаламжийн нэгж, 70 жил хадгалах 20 хадгаламжийн нэгж, 100 найман ойл ХК-ний шатахууны агуулахын ажлын 6 хадгаламжийн нэгжийг төрийн архивт данс бүртгэлийн хамт хүлээн авч 119 хадгаламжийн нэгжээр нөхөн бүрдүүлэлт хийсэн.

Иргэний бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр гадаад паспорт захиалсан -20
- Иргэний үнэмлэх шинээр олгосон -41
- Төрснөө бүртгүүлсэн хүүхдийн тоо- 34
- Гэрлэлт бүртгүүлсэн тоо - 4
- Гэрлэлт цуцлуулснаа бүртгүүлсэн тоо -1

- Үрчлэлтийн бүртгэлийн тоо - 1
- Нас барсныг бүртгүүлсэн тоо - 5
- Өөр аймаг, хотоос шилжиж ирсэн нийт иргэн -41
- Аймаг дотор шилжсэн иргэдийн тоо -46

Эд хөрөнгийн бүртгэлийн чиглэлээр:

- Үл хөдлөх хөрөнгийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 5
- Газар өмчлөх эрхийг анхны удаа баталгаажуулах бүртгэл - 62
- Гэрээний бүртгэл - 36
- Барьцааны гэрээний бүртгэл -135
- Эд хөрөнгөд орсон өөрчлөлт, залруулга -2

Хуулийн этгээдийн бүртгэлийн чиглэлээр:

- Шинээр байгуулагдсан хуулийн этгээдийн бүртгэл - 6
- Хуулийн этгээдийн бүртгэлийн өөрчлөлт -4
- Татан буугдсан хуулийн этгээдийн бүртгэл - 1

Архивын чиглэлээр:

- Төрийн байгууллагад гаргасан лавлагаа, хуулбар -21
- Иргэнд гаргасан лавлагаа, хуулбар-184-ыг олгож, нийт 205 иргэнд төрийн үйлчилгээг хүргэсэн.

Цагдаагийн хэлтэс нь: Аймгийн “Залуус” телевизтэй хамтран зам тээврийн осол, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зорилгоор мэдээ мэдээллийг өдөр тутам 12,18 цагуудад урсдаг зараар олон нийтэд түгээн, хэвлэл мэдээллийн хэрэгслээр сурталчилж, тээврийн хэрэгслийн жолооч нарт 250 санамж сэрэмжлүүлэг тараан ажиллав.

“Ятгах тусам нягтал” аяны хүрээнд дараах арга хэмжээг зохион байгууллаа. Үүнд: Говьсүмбэр телевиз, фм радиогоор залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэд, олон нийтэд мэдээлэл хийлээ.

Аж ахуйн нэгж, байгууллагуудын орох, гарах хаалга болон арилжааны банкуудын тиллер, эдийн засагч нарын компьютер дээр залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлэгийг байршуулав.

Мэргэжлийн ахлагч бэлтгэх төвийн 115 ахлагч, сонсогч нарт залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт зохион байгууллаа

Аймгийн төрийн 35 байгууллагын дарга, нягтлан бодогч нийт 58 алба хаагчид залилах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр мэдээлэл өгч, сэрэмжлүүлэг гарын авлага тараан аянд нэгдүүллээ.

Сэмжүүхэй талх нарийн боовны цехтэй хамтран ажиллаж 5 төрлийн сэрэмжлүүлэг зурагт хуудсыг бүтээгдэхүүний савлагаан дээр нааж иргэдэд хүргэлээ.

Аймгийн хот хооронд болон аймаг дотор үйлчилгээ эрхэлдэг таксины жолооч нартай хамтран автомашины салон дотор болон гадна талд "Ятгах тусам нягтал" стикерийг нааж иргэдэд аяныг сурталчиллаа.

Цэвэр ус түгээдэг аж ахуй нэгжтэй хамтран залилах гэмт хэргийн эсрэг "Ятгах тусам нягтал" наалт стикерийг цэвэр усны саванд нааж иргэд байгууллагуудад сурталчлах ажлыг зохион байгуулж байна.

Шүүхийн шинжилгээний алба нь: Шүүхийн шинжилгээний албанаас хэргийн газрын үзлэгт 25 удаа оролцоноос хүний амь эрсэдсэн хэргийн газрын үзлэгт 2, зам тээврийн ослын 11, хулгайлах гэмт хэрэг 9, бусад хэргийн газрын үзлэгт 3 удаа, задлан шинжилгээнд 3 удаа оролцож хэргийн газраас гарын мөр 2, гутлын мөр 6, тээврийн хэрэгслийн мөр 12, бусад ул мөр эд мөрийн баримт 3-ыг илрүүлэн бэхжүүлж хэргийн материалд хавсаргасан. Хэргийн газрын үзлэгийн болон эд мөрийн баримт, эрэн сурвалжлах, танин олуулах ажиллагаа,

хэргийн газрын давтан үзлэг, нэгжлэг, цогцос задлан шинжлэх зэрэг ажиллагааны 412 кадр гэрэл зургийг боловсруулан холбогдох материалд хавсаргасан.

Тайлант хугацаанд хүний биед гэмтлийн зэрэг тогтоох үзлэг 40 удаа хийж дүгнэлт гаргасан. Мөн 4 цогцосны задлан шинжилгээнд оролцсон.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар-425 дугаар нээлттэй хорих анги нь: 2020 оны 01 дүгээр сард төлбөрийн 38 гүйцэтгэх баримт бичгээс 3 гүйцэтгэх баримт бичгийн 26544,4 мянган төгрөг, 1 хүүхдийн тэтгэлгийн баримт бичгийг бодитой биелүүлж гүйцэтгэх хуудасны бодит биелэлт 9.5 хувьтай ажиллаж байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвд бетон арматурчин мэргэжлээр 12, гагнуурчин мэргэжилээр 15, аймгийн Уул уурхайн жишиг сургууль Политехникийн коллежид Хүнд машин механизмын операторчин мэргэжлээр 12, хүнд машин механизмын засварчин мэргэжлээр 14 хоригдлыг сургаж байна.

Нийгмийн ажилтнууд ажлын өдөр эхний ээлжинд ажлын заалтгүй 100 гаруй хоригдолд хуваарийн дагуу өдөр бүр давхардсан тоогоор 1800 хоригдолд амьдрах ухааны чиглэлийн, Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөлөх бодис хууль бусаар ашигласан 19 хоригдлыг бүлгийн сургалтанд 7 хоногт 2-3 удаа нийт 8 удаа зохион байгуулсан.

Монгол бичгийн дугуйланд 137 хоригдол хамрагдаж байна.

Мөн ардын уламжлал, зан үйлийг сурталчлах түгээн дэлгэрүүлэх, хоригдлуудад эерэг зан үйл төлөвшүүлэх зорилгоор “Шагайн харваа”-ны дугуйланд анхан, дунд шатны мэдлэгтэй хоригдлуудыг хамруулж байна. Шинээр ирсэн хоригдлууд “Угийн бичиг” хөтлөх арга зүйн сургалтанд хамруулсан бөгөөд сургалтын үр дүнд 28 хоригдол угийн бичиг хөтөлж эхэлсэн.

Насан туршийн боловсрол олгох төвтэй хамтран бичиг, үсгийн чадваргүй 1 хоригдлыг сургалтанд хамруулж бичиг, үсгийн чадвартай болгосон.

Согтууруулах ундаа хэрэглэн гэмт хэрэг үйлдсэн архины хамааралтай гэх 62 хоригдолд батлагдсан хөтөлбөрийн дагуу сургалтыг зохион байгуулсан.

Мэргэжлийн хяналтын газар нь: Урьдчилан сэргийлэх шалгалт 1, төлөвлөгөөт бус хяналт шалгалт 4 удаа хийж, улсын байцаагчийн зөвлөмж 1, зөвлөн туслах үйлчилгээ 1, дүгнэлт 6, албан шаардлага 1-ийг боловсруулан холбогдох аж ахуй нэгжүүдэд хүргүүлсэн.

Хүнсний чанар, стандартын хяналтын улсын байцаагч, эрүүл ахуй халдвар хамгааллын хяналтын улсын байцаагч болон аж ахуй нэгж байгууллага, иргэний хүсэлтээр ирүүлсэн усны 4, гурилан бүтээгдэхүүний 6, агаар 2, мах, махан бүтээгдэхүүний 2, арчдас 10, нийт 26 дээжинд 130 үзүүлэлтээр хими, нян судлалын шинжилгээг хийж гүйцэтгэсэн.

Аймгийн Боловсрол, соёл, урлагийн газраас ирүүлсэн хүсэлтийн дагуу цэцэрлэг болон сургуулийн үдийн цай, дотуур байрны тогооч нарт сургуулийн орчинд худалдах болон хүүхдийн хоол үйлчилгээнд хэрэглэхийг хориглосон бүтээгдэхүүний тухай, хоол үйлчилгээнд мөрдөх эрүүл ахуйн болон үйлдвэрлэлийн зохистой дадлыг хэвшүүлэх, хэрэгжүүлэх, хүнсний температурын хяналтыг сайжруулах, ажилчдыг хувийн зөв дадалд хэвшүүлэх зорилгоор 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдөр сургалт зохион байгуулж, нийт 13 байгууллагын 26 тогоочийг хамруулсан.

Онцгой байдлын газар нь: 01 дүгээр сарын 16-ны өдөр аймгийн Онцгой комисс хуралдаж аймгийн аюулгүйн нөөцийн өвсийг хавар мал төллөх үеэр гаргах, сумдын аюулгүйн нөөцийн өвсийг малчдад үнэгүй тараах, шийдвэрийг гаргасан.

Гал унтраах тархалтын сургуулийг “Зүүн жанжин Чойрын хийд, Монсульт ШТС, Ус-Ду ХХК-ны уурын зуухны хэсэгт гарсан гал түймрийг унтраах талаар сургалтыг хамтран зохион байгуулсан.

Тайлант хугацаанд аймгийн хэмжээнд гал түймрийн 2 удаагийн дуудлага бүртгэгдэж гал түймэр унтраах аврах 37 дугаар ангийн бие бүрэлдэхүүн 2 удаагийн гал түймэр дээр гал унтраах байлдааны тархалт хийж 4,6 тн ус, 155 литр шатахуун зарцуулан иргэд, аж ахуй

нэгжийн 8 сая төгрөгийн эд хөрөнгийн авран хамгаалж, 3 сая төгрөгийн эд хөрөнгө гал түймэрт өртөж шатсан байна.

ДӨРӨВ. БОЛОВСРОЛ,СОЁЛ, ЭРҮҮЛ МЭНД, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Боловсролын чиглэлээр: Боловсролын хүрээлэнгийн хүний хөгжлийн сектортой хамтран “Судалгааны ажил, илтгэл бичих арга зүй” сэдвээр сургалт зохион байгууллаа. Сургалтанд сургууль цэцэрлэгийн удирдлагууд, багш нар нийт 100 хүн хамрагдлаа.

2020 оны шилдэг илтгэл шалгаруулах эрдэм шинжилгээний бага хурлыг зохион байгуулж, улсын уралдаанд оролцох илтгэлийг шалгаруулсан. Илтгэлийн уралдаанд 17 илтгэгч багш оролцлоо.

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Цэргийн штаб, Боловсрол, соёл урлагийн газар, Уул уурхайн жишиг сургууль политехник коллежийн ахлагч бэлтгэх төвийн ахлагч нараар ахлуулсан баг “Хүүхэд, залуучуудад эх оронч үзэл төлөвшүүлэх үндэсний хөтөлбөр”-ийг танилцуулах сургалтыг ерөнхий боловсролын сургуулийн дунд, ахлах ангийн сурагчдад энэ сарын 25-ны өдөр амжилттай зохион байгуулсан.

01 дүгээр сарын 25-ны өдөр “Олонлог” ерөнхий боловсролын сургуулийн физикийн багш Б.Магсар "Физикийн бодлого бодох арга зүйд суралцах нь" сэдвээр сургалт зохион байгуулсан. Тус сургалтанд физикийн 9 багш хамрагдлаа.

2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр Дэлхийн зөн олон улсын байгууллагатай хамтран “Хүмүүжлийн эерэг арга” сэдэвт сургалтыг зохион байгуулсан. Сургалтанд ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн удирдах ажилтан, багш нарыг хамруулсан. Сургалтын үр дүнд Монгол хүүхдийн хөгжлийн цогц судалгааг өөрийн ажил, хэрэгт чиглэл болгон ашиглаж, хүүхдийн хувийн онцлог, ялгаатай байдлыг харгалзан сургалт, хүмүүжлийн ажил зохион байгуулах арга зүй болон хүүхдийн хөгжлийг судлах арга зүйд тус тус суралцсан.

Биеийн тамир, спортын чиглэлээр: 2020 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр Дэлхийн зөн Бор-Өндөр 1 Орон нутгийн хөгжил, аймгийн Шатрын холбоотой хамтран хүүхэд багачуудын дунд шатрын спортыг сурталчлан, авьяас билгийг нээн хөгжүүлэх, ирээдүйн мастеруудыг бэлтгэх, шатрын спортоор дамжуулан хүүхэд багачуудыг төлөвшүүлэх зорилготой өсвөрийн шатарчдын “Цодгор хүү-2020” тэмцээнийг зохион байгуулж, 4 насны ангилалд 3 сумын 72 хүүхэд хамрагдсан.

Эрүүл мэндийн чиглэлээр:

Үзүүлэлт	2019 оны 01 сар	2020 оны 01 сарын 20-ны байдлаар
Төрсөн эх	38	32
Гэрийн төрөлт	0	0
Амьд төрсөн хүүхэд	38	32
Амьгүй төрөлт	0	0
Нас баралт	3	2
Эмнэлгийн нас баралт	2	0
Хоног болоогүй нас баралт	0	0
0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	2	0
1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	0	0
Эмнэлгээс гарсан хүний тоо	530	58
Амбулаторийн үзлэг	1000	2565
Халдварт өвчин	8	5

Аймгийн Эрүүл мэндийн төвүүдэд 2020 оны хэрэгцээт эм, эмнэлгийн хэрэгсэл нийлүүлэх ГСАЭМГ/202012001 дугаартай /15 багцтай, нийт 35.305.306 төгрөгийн төсөвт

өртөгтэй/ цахим тендер шалгаруулалтын анхны нээлт 2019 оны 12 дугаар сарын 30-ны өдөр болсон. Тус тендерийн 7 багцад 3 аж ахуйн нэгж оролцон үнийн санал ирүүлж, 6 багцад оролцогч шалгаран 17.517.636 төгрөгийн гэрээ байгуулсан.

2020 оны 01 дүгээр сарын 3 дахь долоо хоногийн байдлаар томуу, томуу төст өвчин амбулаторийн үзлэгийн 14.1 хувийг эзэлж байна. Томуу, томуу төст өвчин 0-11 сартайд 34.5 хувь, 0-5 насанд 82.0 хувь, 5-9 насанд 29.0 хувь, 0-15 насанд 94.1 хувь бүртгэгдсэн байна.

Томуу, томуу төст өвчнөөс сэргийлэх мэдээлэл, сургалт сурталчилгаа, гарын авлага, эмчийн зөвлөгөө мэдээллийг орон нутгийн телевиз, ерөнхий боловсролын сургуулиудын эмч, нийгмийн ажилтнууд, цэцэрлэгүүдэд коронавирусээс сэргийлэх 7 төрлийн гарын авлага материалыг тараасан.

ТАВ. ХӨДӨӨ АЖ АХУЙН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Мал, аж ахуйн чиглэлээр: Улсын аварга малчин өрх, Улсын хошой аварга малчин өрх шалгаруулах журмын дагуу болзол хангасан 3 малчин өрхийн материалыг аймгийн Засаг даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яаманд хүргүүлсэн.

Малчин болон мал бүхий этгээдийн 2019 онд бэлтгэн үндэсний үйлдвэрт тушаасан арьс ширэнд урамшуулал олгуулахаар 1003 баримтын мэдээллийг цахим санд оруулсан.

Онцгой байдлын газарт өвөлжилтийн эрсдэлийн үнэлгээ гаргахтай холбогдуулан 14 хоног тутам өвөлжилтийн мэдээ өгч ажиллаж байна.

Малх отрын бүсээс гадна аймгийн нутаг дэвсгэрт 21 өрхийн 44460 толгой мал отроор өвөлжиж байна. Малх отрын бүсэд 5 аймгийн 10 сумын 91 өрхийн 111000 толгой мал /хонин толгойд шилжүүлснээр/ өвөлжиж байна. Отрын нөхцөл байдалтай танилцаж, нэмэгдсэн Дундговь, Хэнтий, төв, Өвөрхангай аймгийн 10 өрхтэй гэрээ байгуулсан.

Жижиг дунд үйлдвэрлэлийг хөгжүүлэх сангаас зээлийн дэмжлэг авсан Сүмбэр буянт ХХК-ийн Шимт хүнс төслийн хэрэгжилтийн үйл ажиллагаатай танилцсан.

Аймгийн төвийн захууд, томоохон худалдааны төвүүдийн хүнсний бараа бүтээгдэхүүний үнийг өнгөрсөн сарын үнэтэй харьцуулан гаргасан 2020 оны 01-р сарын үнийн мэдээ

Есдүгээр сарын сүүлч 1 дүгээр сарын эхээр малчдаас зах зээлд нийлүүлэгдэж буй махны нийлүүлэлт ихсэж байгаа тул зах зээлд худалдаалагдаж буй Үхрийн /ястай, цул/ махны үнэ 500 төгрөгөөр, ямааны мах /ястай/ 500 төгрөгөөр төмс болон зарим, хүнсний ногооны үнэ өнгөрсөн сараас 50-200 төгрөгөөр нэмэгдсэн үзүүлэлттэй байна. Бусад бараа бүтээгдэхүүний үнэ тогтвортой байна.

№	Бараа бүтээгдэхүүн		Дээд үнэ төг	Доод үнэ төг	Өссөн буурсан
1	Үхрийн мах	ястай	8500	6000	+500
		цул	10000	10000	+500
2	Хонины мах	ястай	6500	4500	-
		цул	9000	8500	-
3	Адууны мах	ястай	6500	5000	-
		цул	9500	9000	-
4	Ямааны мах	ястай	5000	4000	+500
		цул	9000	8500	-
5	Тахианы мах	гуя	8500	8500	
		мөч	9200	8500	
6	Лууван	монгол	2000	1500	-
		хятад			

7	Төмс	МОНГОЛ	1000	500	+50
		Хятад			
8	Байцаа	МОНГОЛ	1500	1200	
		Хятад			-
9	Чинжүү	МОНГОЛ			-
		Хятад	7000	6800	
10	Манжин	МОНГОЛ	1200	1200	+50
		Хятад			-
11	Сонгино бөөрөнхий	МОНГОЛ	2000	1600	-
		Хятад	1600	1200	-
12	Улаан лооль	МОНГОЛ	6000	5500	-
13	Өргөст хэмх	МОНГОЛ	3500	3000	-
14	Элсэн чихэр	МОНГОЛ	2100	1800	-
15	Будаа	цагаан будаа задгай кг	2500	2000	-
		шар будаа слава кг	3100	2900	-
		гурвалжин будаа кг	3800	2200	-
16	Сүү	задгай	2000	1500	-
		сүү ХХК 0,5л			
		сүү ХХК 1л	3000	2950	-
17	Тараг	задгай	2500	2000	-
		сүү ХХК 1л цөцгийтэй тараг	4800	3800	-
18	Талх	Чойр талх	1200	800	-
19	Өндөг	ОХУ	450	300	-5
		Монгол	400	250	-15
20	Алтан тарианы гурил	задгай дээд	1480	1400	-
		задгай 1-р зэрэг	1100	1080	-
		задгай 2-р зэрэг	1000	950	-
		савласан д/дээд /	1650	1600	-
		савласан дээд	1650	1600	-
		савласан 1-р зэрэг	1300	1200	-
		савласан 2-р зэрэг	1500	1450	-
21	Ургамлын тос	oleyна	5500	4800	+50
		алтан	3800	3600	-
22	Гоймон	aleyка	1600	1500	-
		а/тариа савхан	1000	900	-

ЗУРГАА. БАЙГАЛЬ ОРЧИН, ҮЙЛДВЭР, ҮЙЛЧИЛГЭЭ, ДЭД БҮТЦИЙН САЛБАРЫН БОДЛОГЫН ХҮРЭЭНД

Байгаль орчны чиглэлээр: Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Нөхөрлөлийн тухай хууль, нөхөрлөлүүдийн үндэсний чуулганаас гаргасан зөвлөмжийн дагуу аймагт үйл ажиллагаа явуулж буй Байгалийн нөөцийн хамтын менежментийн нөхөрлөлийн гишүүдийг чадавхжуулах сургалтыг 2020 оны 01 дүгээр сарын 17-ны өдөр зохион байгууллаа. Тус сургалтанд Байгалийн нөөцийн хамтын менежментийн “Хээнций уул”, “Уулзварын гол” нөхөрлөлийн гишүүд хамрагдаж, Байгаль орчны талаар төрөөс баримталж буй бодлого, улс болон аймаг орон нутгийн зүгээс хэрэгжүүлсэн арга хэмжээний талаарх мэдээлэл хүргэж, нөхөрлөлүүдийн 2019 онд хийж хэрэгжүүлсэн ажлын тайлантай танилцаж, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал солилцсон.

Ус цаг уур орчны шинжилгээний төвөөс 01 дүгээр сард 8 хугацааны мэдээг нийт 248, климат агро дундаж хөдөө аж ахуйн тойм болон 10 хоногийн тойм мэдээг нийт 3, сарын тойм мэдээг 1 удаа тус тус төв станцад дамжуулсан.

01 дүгээр сарын цаг уурын тойм мэдээгээр: 9-нд нутгийн инхэнх хэсгээр цас орж нийт 1,0 мм тунадастай, Салхи ихэнхи хугацаанд 3-8 м/сек байв. Агаарын дундаж температур 18.1 градус хүйтэн, хамгийн хүйтэн нь 01-ний шөнө 26.1 градус хүйтэн, хамгийн дулаан нь 04-ний өдөр 4.6 градус дулаан байсан.

Энэ сард агаар бохирдуулагч элементүүд болох азотын давхар исэл (NO₂), хүхэрлэг хийн давхар ислийг (SO₂) хоногт 3 удаа нийт 39 сорьцыг авч шинжилгээ хийлээ. 01 дүгээр сарын 01-20-ны өдрүүдийн дээжинд шинжилгээ хийсэн ба шинжилгээний дүнгээр дундажлахад азотын давхар исэл (NO₂) 0.015, сарын хүлцэх агууламж нь 0.050, хүхэрлэг хийн давхар исэл (SO₂) 0.018 байгааг харахад хүлцэх агууламжаас давсан бохирдол ажиглагдаагүй байна.

Тээвэр, авто замын талаар: Тээврийн хэрэгслийн техникийн үзлэг оношилгоонд 2020 оны 01 дүгээр сарын 25-ны байдлаар 129 тээврийн хэрэгсэл хамрагдсан.

Хот хооронд 409 иргэн зорчиж, 54 тээврийн хэрэгслийн шилжилт хөдөлгөөн хийгдэн, 200 замын хуудас олгосон байна.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалт, хөрөнгө оруулалтын талаар:

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны 09 дүгээр тогтоолоор 2020 онд газрын төлбөрийн орлого 200 сая төгрөг төвлөрүүлэхээр төлөвлөгөө батлагдсан бөгөөд 1 сарын байдлаар 54.684.362 сая төгрөг төвлөрүүлж, төлөвлөгөөний биелэлт 27.4 хувьтай байна. Үүнд:

- 5 аж, ахуйн нэгжээс –54.573.548 төгрөг
- 18 иргэдээс-110.814 төгрөгийг тус тус төвлөрүүлээд байна.

Баянтал сумын 2020 оны газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний дагуу сумын Засаг даргын 2020 оны А/02 дугаартай захирамжаар 4 байршилд газар эзэмшүүлэх, ашиглуулах эрхийн гэрчилгээний дуудлага худалдааг зохион байгуулахаар газрын цахим бирж болох www.mle.mn сайт болон Өдрийн сонин, Залуус ТВ, байгууллагын сайт, мэдээллийн самбар зэргээр зарыг байршуулаад байна.

Хот байгуулалтын чиглэлээр:

Барилга, хот байгуулалтын яам болон Нийслэлийн орон сууцны дэд бүтцийн газар, хот байгуулалт, хөгжлийн газруудтай хамтран 2020 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр гэр хорооллыг дахин төлөвлөн барилгажуулах, ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн орон сууцыг дахин төлөвлөн барилгажуулах төслүүдтэй танилцаж туршлага судалсан.

Худалдан авах ажиллагааны талаар: 2020 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дагуу 75 төсөл арга, хэмжээний үнэлгээний хороог байгуулж, худалдан авах ажиллагааг зохион байгуулж ажиллахаас 22 үнэлгээний хорооны захирамжийг гаргуулан, 10 ажлыг зарлаад байна.

ДОЛОО. СУМ ОРОН НУТГИЙН ТАЛААР

Баянтал сум:

Сумын Засаг даргын 2020 оны 01 дүгээр сарын 05-ны өдрийн А/82 тоот захирамжаар томилогдсон 13 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг нь жилийн эцсийн хүн ам, мал амьтны тооллогыг 2019 оны 12 дугаар сарын 07-17-ны өдрүүдэд зохион байгууллаа. 2019 оны жилийн эцсийн байдлаар 70684 толгой мал тоологдлоо.

2020 оны орон нутаг хөгжил сангийн хөрөнгөөр хийгдэх бараа, ажил үйлчилгээний төлөвлөгөө болон төсвийн задаргааг сумын цахим хуудас, мэдээлэл сурталчилгааны самбаруудад байршуулан ил тод зарлан ажиллаж байна.

Сумын ерөнхий боловсролын сургуулийн багш нарын дунд “Ажлын байрандаа хөгжье” сургалтыг багш нарын харилцаа, эрх зүйн мэдлэгээ дээшлүүлэх, цахим журнал хөтлөх арга зүй сэдвээр сургалт зохион байгуулсан.

Сүмбэр сум:

2020 оны 01 дүгээр сарын 02-ны өдөр 5, 6 дугаар багуудад отроор өвөлжиж байгаа Дундговь аймгийн Эрдэнэдалай сумын харьяат 3 өрхөөр орж, орон нутгийн бодлого шийдвэрийг танилцуулан, бэлчээр чөлөөлөх асуудлаар үүрэг чиглэл өгсний дагуу 400 бод, 2000 гаруй богтой айлуудыг 6 дугаар багийн “Найман хонд” гэдэг газраас нүүлгэн шилжүүлсэн.

Сүмбэр сумын хэмжээнд урьдчилсан дүнгээр 2019 оны жилийн эцэст 325928 толгой мал тоолуулсан нь урьд оноос 16216 толгой буюу 5.2 хувиар өссөн дүнтэй байна. Оны эцэст малчин өрх 524 болж 1.1 хувиар, малчин 836 болж 1.8 хувиар тус тус буурсан байна.

Шивээговь сум:

Сумын Засаг даргын 2019 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн А/173 дугаар захирамжаар томилогдсон ажлын хэсэг жилийн эцсийн хүн ам, мал тооллогын ажлыг зохион байгууллаа. 2019 оны жилийн эцсийн байдлаар 55392 толгой мал тоологдсон.

Үндсэн хуулийг эрхэмлэн дээдлэх өдрийг угтаж 01 дүгээр сарын 13-ны өдөр иргэдэд шинээр батлагдсан Үндсэн хуулийн талаарх мэдээллийг хүргэж, хуультай холбоотой гарын авлага материал тарааж, арга хэмжээнд оролцсон иргэдийн дунд АХА тэмцээн зохион байгууллаа.

Сумын 1, 2 дугаар багийн хурлыг 2020 оны 01 дүгээр сарын 15, 17-ны өдрүүдэд зохион байгуулж, 2021 оны Орон нутаг хөгжил сангийн хөрөнгөөр хийгдэх ажлын саналыг авах ажлыг эхлүүлж, 169 иргэнээс авсан. Мөн сумын Засаг дарга болон багийн Засаг дарга нар 2019 онд хийсэн ажил, 2020 онд хийх ажлын төлөвлөгөөгөө танилцуулж, шинээр батлагдсан болон шинэчлэн өөрчлөгдсөн хуулиудаар сургалт зохион байгуулсан.

Сумын 2020 оны Орон нутаг хөгжил сангийн 268.8 сая төгрөгийн хөрөнгөөр хийгдэх 17 арга хэмжээний төлөвлөгөөг сумын Засаг даргаар батлуулан tender.gov.mn, шилэн данс, Сангийн яамны сайт, shivee.gov.mn зэрэг цахим хуудаст байршууллаа.

Аймгийн Эрүүл мэндийн газартай хамтран амны хөндийн үзлэг, эмчилгээг 01 дүгээр сарын 20-ны өдрөөс 7 хоногийн хугацаанд зохион байгуулан ажиллаж, амны хөндийн үзлэгт 1-2 дугаар ангийн 6 бүлгийн 161 сурагч хамрагдаж, 126 сурагч өвчлөлтэй буюу шүдний өвчлөлийн тархалт 78.6 хувьтай байна. Үүнээс эмчилгээнд хамрагдах шаардлагатай 105 сурагч буюу 83.3 хувь эмчилгээ хийлгэхээс 33 хувь нь буюу 39 сурагчийг эмчилгээнд хамруулаад байна.